

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД,
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/257, А/252

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.1.23, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Засгийн газрын 2017 оны 274 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр” 2018-2022 он -ийн 4.14, 4.15 -т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тушаалын хавсралтаар баталсан журмыг хэрэгжүүлж ажиллахыг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ /Ц.Амарсанаа/, Эрчим хүчний зохицуулах хороо /А.Тлейхан/-нд тус тус даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох нарт тус тус үүрэг болгосугай.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД



Барилга, хот байгуулалтын сайд
Эрчим хүчний сайдын 2021 оны 22
дугаар сарын 20-ны өдрийн А/257, А/252
хамтарсан тушаалын хавсралт

БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын нутаг дэвсгэрт шинээр төлөвлөх, өргөтгөх, шинэчлэх, сэргээн засварлах, ашиглагдаж буй барилга байгууламжийн эрчим хүчний хэрэгцээ, хэрэглээний үр ашгийн үзүүлэлтийг баталгаажуулан гэрчилгээ олгохтой холбогдон үүсэх аливаа харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Энэ журмын зорилго нь барилгад хүн ажиллах, амьдрах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардагдах дотоод орчны бичил уур амьсгалын нөхцөлийг хангахад шаардагдах эрчим хүчний үзүүлэлтийг тодорхойлон, гэрчилгээжүүлэх замаар барилгын насжилтыг уртасгах, ашиглалтын хугацааны зардлыг бууруулах, ногоон, эрчим хүчний хэмнэлттэй болон пассив барилгын үнэлгээний системд шалгуур үзүүлэлтийг тогтоох, үнэлэх суурь нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

1.3 Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох үйл ажиллагаанд Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль болон холбогдох норм, нормативын баримт бичгийг удирдлага болгоно.

Хоёр. Барилгын эрчим хүчний гэрчилгээ

2.1. Барилгын эрчим хүчний гэрчилгээг барилгын Дулаан хамгаалалтын нормыг үндэслэн боловсруулах ба энэ журмын хавсралтад заасан агуулга, загвар, дугаарлалттай байна.

2.2 Барилгын зураг төслийн магадлалын шатанд эрчим хүчний гэрчилгээ олгоно. Зураг төслийн магадлалын шатанд барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох үйл ажиллагааг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

2.3 Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 3.1.8-д заасан иргэн, аж ахуйн нэгж байгууллага болон бусад ашиглагдаж байгаа барилгад эрчим хүчний гэрчилгээ олгох үйл ажиллагааг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл хариуцна.

2.4 Барилгын эрчим хүчний гэрчилгээг хугацаатай олгох ба зураг төслийн магадлалын шатанд олгосон гэрчилгээ нь Барилгын тухай хуулийн 14.6-д заасан хугацаанаас, ашиглагдаж байгаа барилгын гэрчилгээ нь Барилгын тухай хуулийн 46.1.14-т заасан хугацаанаас тус тус хэтрэхгүй байна.

Гурав. Гэрчилгээ олгох үйл ажиллагаа

3.1 Энэ журмын 2.2-т заасан барилгын эрчим хүчний гэрчилгээг дараах баримт бичгийг үндэслэн олгоно:

3.1.1. захиалагчийн албан хүсэлт;

3.1.2. холбогдох норм, нормативын баримт бичгийн дагуу тооцсон тухайн барилгын эрчим хүчний үзүүлэлт;

3.1.3. барилгын зураг төслийн халаалт, агаар сэлгэлтийн бүрдэл хэсэгт магадлал хийсэн дүгнэлт, эсхүл барилгын эрчим хүчний аудитын дүгнэлт.

3.2 Энэ журмын 2.3-т заасан барилгын эрчим хүчний гэрчилгээг дараах баримт бичгийг үндэслэн олгоно:

3.1.4. барилгын өмчлөгч, эзэмшигчийн албан хүсэлт;

3.1.5. холбогдох норм, нормативын баримт бичгийн дагуу тооцсон тухайн барилгын эрчим хүчний үзүүлэлтийг тооцсон барилгын эрчим хүчний аудитын дүгнэлт, тайлан;

3.1.6. зураг төслийн шатанд гэрчилгээ авсан бол гэрчилгээний эх хувь;

3.3 Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгогч баримт бичгийн бүрдлийн үнэн бодит байдлыг тодруулах зорилгоор нэмэлт мэдээлэл, лавлагаа авах, барилгад хэмжилт хийх, мэргэжлийн нэмэлт дүгнэлт хийлгэх ажлыг зохион байгуулж болно.

3.4 Энэ журмын 3.1, 3.2-т заасан баримт бичгийн бүрдэл нь шаардлага хангасан бол барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох асуудлыг хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.5 Энэ журмын 3.3-т заасан нөхцөл байдал үүсвэл гэрчилгээ олгох хугацааг нэг удаа ажлын 10 хоногоор сунгаж болно.

3.6 Барилгын эрчим хүчний гэрчилгээг үрэгдүүлсэн бол гэрчилгээний хүчинтэй хугацаанд барилгын эзэмшигч дахин хүсэлт гарган олгосон байгууллагаас шинээр авна.

3.7 Гэрчилгээ бүхий барилгыг бүртгэх, мэдээллийн сан үүсгэх, цахимд ил тод байршуулах ажлыг энэ журмын 2.2, 2.3-т заасан байгууллага хариуцах ба мэдээллийг тогтмол солилцоно.

3.8 Гэрчилгээ олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор цахим системийг ашиглана.

Дөрөв. Барилгын эрчим хүчний гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг

4.1 Барилгын эрчим хүчний гэрчилгээ эзэмшигч нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

4.1.1 барилгын эрчим хүчний гэрчилгээ олгоход шаардлагатай мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх;

4.1.2 зураг төслийн магадлалын шатанд эрчим хүчний гэрчилгээ эзэмшигч нь энэхүү журмын 2.4-д заасан хугацаанд барилгын эрчим хүчний гэрчилгээг авах.

4.1.3 энэ журмын 2.4 заалт дахь хугацаанд барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх, их засвар хийх зэргээр эрчим хүчний хэрэглээнд өөрчлөлт орсон, гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд барилгын эрчим хүчний аудит хийлгэн гэрчилгээг шинээр авах.

4.1.4 гэрчилгээ авахтай холбогдон гарах зардал, төлбөрийг хариуцах.

4.1.5 барилгын эрчим хүчний гэрчилгээний үзүүлэлтийг дээшлүүлэх арга хэмжээг авах.

4.2 Барилгыг худалдан борлуулах, түрээслэхдээ үйлчлүүлэгч, хэрэглэгчийг мэдээллээр хангах зорилгоор эрчим хүчний гэрчилгээг нүдэнд ил харагдах газар байрлуулж, сурталчилж болно.

Тав. Бусад

5.1 Барилгын эрчим хүчний гэрчилгээг өмчлөгч, эзэмшигчид хоёр эх хувь олгож, хуулбар хувийг баримт бичгийн бүрдлийн хамт архивлана.



5.2 Барилгын эрчим хүчний үзүүлэлтийг тодорхойлох мэргэжлийн /эрчим хүчний аудитын, магадлалын/ дүгнэлтийг чанаргүй эсхүл буруу гүйцэтгэснээс гарах үр дагавар, зардлыг мэргэжлийн дүгнэлт гаргасан эрх бүхий этгээд хариуцна.

5.3 Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгохтой холбогдон үүсэх аливаа санал, хүсэлт, гомдлыг гэрчилгээ олгогч байгууллага харьяаллын дагуу хүлээн авч холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

5.4 Энэхүү журмын 5.3-т заасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд шүүхэд гомдол гаргаж болно.

---oOo---

Барилгын эрчим хүчний гэрчилгээний загвар, агуулга

БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ГЭРЧИЛГЭЭ																	
Бүртгэлийн дугаар: ЗТ-1-1/0001/2020	Олгосон огноо: 2020 он 12 сар 18 өдөр	Хүчинтэй хугацаа: 20.. он .. сар .. өдөр															
Гэрчилгээний төрөл: Ашиглалт	Барилгын зориулалт: Сургууль																
Барилгын нэр: 48-р сургууль	Ашиглалтад орсон он: 1971																
Барилгын байршлын хаяг																	
Хот, аймаг: Улаанбаатар хот	Дүүрэг, сум: Баянзүрх																
Хороо, баг: 1-р хороо	Барилгын дугаар: 48-р сургууль																
Гудамжны нэр: Их тойруу	Барилгын дугаар: 13380																
Эрчим хүчний хэрэгцээний ангилал																	
<p>эрчим хүчний хэмнэлттэй</p> <table style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr><td style="background-color: #006400; color: white; text-align: center; padding: 2px;">A++</td><td style="text-align: center; padding: 2px;">< 20%</td></tr> <tr><td style="background-color: #008000; color: white; text-align: center; padding: 2px;">A+</td><td style="text-align: center; padding: 2px;">20%-40%</td></tr> <tr><td style="background-color: #00A000; color: white; text-align: center; padding: 2px;">A</td><td style="text-align: center; padding: 2px;">40%-65%</td></tr> <tr><td style="background-color: #00C000; color: white; text-align: center; padding: 2px;">B</td><td style="text-align: center; padding: 2px;">65%-90%</td></tr> <tr><td style="background-color: #FFA500; color: white; text-align: center; padding: 2px;">C</td><td style="text-align: center; padding: 2px;">90%-110%</td></tr> <tr><td style="background-color: #FF4500; color: white; text-align: center; padding: 2px;">D</td><td style="text-align: center; padding: 2px;">110%-160%</td></tr> <tr><td style="background-color: #FF0000; color: white; text-align: center; padding: 2px;">E</td><td style="text-align: center; padding: 2px;">160%<</td></tr> </table> <p style="font-size: small;">эрчим хүчний хэмнэлттүй</p>	A++	< 20%	A+	20%-40%	A	40%-65%	B	65%-90%	C	90%-110%	D	110%-160%	E	160%<	39	63	162
A++	< 20%																
A+	20%-40%																
A	40%-65%																
B	65%-90%																
C	90%-110%																
D	110%-160%																
E	160%<																
	39	63	162														
Барилгын эрчим хүчний кувийн бодит хэрэгцээ:		197	кВт-цаг/(м ² жил)														
Барилгын эрчим хүчний жилийн бодит хэрэгцээ:		1535018	кВт-цаг/жил														
Хүлээжгийн хийн ялгарлын хэмжээ CO2:			тонн/жил														
Гүйцэтгэсэн/хянасан аудитор/инженерийн нэр:		Т.Ганзориг	/барилгын эрчим хүчний аудитор/														
Цахим хаяг:		taek_ganaa@yahoo.com	Утас 1: 95122716														
Гарын үсэг:		Утас 2: 99033553														
Гэрчилгээ олгосон байгууллага:																	
Гэрчилгээ олгосон эрх бүхий байгууллагын лого хууль, журам, нормативын баримт бичгийг үндэслэн-д олгов.																

Эрчим хүчний үр ашгийн ангиллыг харуулсан өнгөний код

эрчим хүчний хэмнэлттэй	
A++	< 20% RGB 0, 102, 0
A+	20%-40% RGB 0, 153, 0
A	40%-65% RGB 51, 204, 51
B	65%-90% RGB 102, 255, 102
C	90%-110% RGB 255, 192, 0
D	110%-160% RGB 255, 102, 0
E	160%< RGB 255, 0, 0
эрчим хүчний хэмнэлттүй	

